

ИННОВАЦИ

АЮУЛГҮЙ
БАЙДАЛ

ЧАНАР


InnoLab
Analysis & Research

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

ИННО ЛАБОРАТОРИ

- ХҮНС
- УС
- ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Инно лабораторийн ИТГЭМЖЛЭЛ

Инно Лаборатори нь ISO/IEC 17025 стандартын шаардлагад нийцсэн чанарын удирдлага, техникийн чадавх бүхий орчин үеийн аналитик лаборатори юм.

Бидний зорилго бол Монгол Улсад олон улсын түвшний шинжилгээний чанарыг нутагшуулах, үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч байгууллагуудад найдвартай аналитик шийдэл хүргэхэд оршино.



ТУРШЛАГА

Инно лабораторийн

Инно лаборатори нь хувийн хэвшлийн шинжилгээ, судалгаа, сургалт, зөвлөх үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа эрхэлж буй лаборатори юм.


Шинжлэх ухаанд суурилсан хяналт, чанарын баталгааг бий болгохын төлөө нэгдсэн мэргэжлийн баг.

ХОЛБОО БАРИХ




80097727

БАГИЙН ГИШҮҮД



Ахлах химич
Г.Болдбаатар




Химич
П. Сайнзаяа



Чанарын менежер
Д. Номинцэцэг



Харилцагч үйлчилгээний ажилтан
Э. Амаржаргал



Химич
Б. Дөлгөөн



Химич
М. Анхчимэг

Дэлгэрэнгүй мэдээлэл

Инно Лаборатори

Innochem.Lab



Инно лабораторийн

AGILENT TECHNOLOGIES

(GC-MS)

Техник технологийн хүчин чадал

ХИЙН ХРОМАТОГРАФ – МАСС СПЕКТРОМЕТР

Дэгдэмхий болон хагас дэгдэмхий органик нэгдлүүдийг ялган таних, бүтэц тогтоох, бага агууламжийг өндөр мэдрэмжээр тодорхойлох зориулалттай аналитик систем. Пестицидийн үлдэгдэл, PAHs, уусгагчийн үлдэгдэл, VOC болон бусад органик бохирдуулагчийн шинжилгээнд өргөн хэрэглэгдэнэ.

AGILENT TECHNOLOGIES

(HPLC)

ШИНГЭНИЙ ХРОМАТОГРАФ

Дулаанд тогтворгүй, дэгдэмхий бус болон биологийн идэвхт нэгдлүүдийг ялган тодорхойлох өндөр нарийвчлалтай арга. Амин дэм, амин хүчил, микотоксин, эмийн бодис, хүнсний нэмэлт зэрэг олон төрлийн бодисын чанарын болон тоон шинжилгээнд ашиглагдана.

AGILENT TECHNOLOGIES

(ICP-OES)

ИНДУКЦИЙН ХОЛБООСТ ПЛАЗМЫН СПЕКТРОМЕТР

Металл болон микроэлементийн агууламжийг ppm-ppb түвшинд өндөр мэдрэмжээр тодорхойлох төхөөрөмж. Хүнс, ус, хөрс, түүхий эд дэх хүнд металл (Pb, Cd, As, Hg гэх мэт) болон эрдэс элементийн шинжилгээнд хэрэглэнэ.

SHINE

(IC)

ИОН ХРОМАТОГРАФ

Усанд уусдаг анион, катион болон органик хүчлүүдийг ялган тодорхойлох арга. Усны чанарын үзүүлэлт, нитрат, нитрит, фтор, хлорид, сульфат зэрэг ионуудын шинжилгээнд өргөн ашиглагдана.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

www.innochem.mn



Холбоо барих
sales@innochem.mn

Тоног төхөөрөмжийн дагалдах үйлчилгээ

InnoLab нь дээрх аналитик тоног төхөөрөмжүүдийг лабораторийн шинжилгээнд ашиглахаас гадна дараах цогц үйлчилгээг үзүүлдэг:

- Ашиглалт, арга зүйн сургалт – GC-MS, HPLC, ICP, IC системийн суурилуулалт, ажиллагаа, арга боловсруулах болон баталгаажуулах сургалт
- Нийлүүлэлт, суурилуулалт – Шинэ тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, лабораторийн орчны бэлтгэл
- Сэлбэг хэрэгсэл, урсгал материал – Колонк, ламп, стандарт бодис, хэрэглээний материалын тогтмол хангалт
- Техникийн үйлчилгээ, засвар – Урьдчилан сэргийлэх үйлчилгээ, оношилгоо, калибровк
- Арга зүйн зөвлөгөө – Шинжилгээний арга боловсруулах, оновчлох, стандартын нийцэл хангах

Бид хэрэглэгч байгууллагуудын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах чиглэлээр урт хугацааны техникийн дэмжлэг үзүүлдэг.

InnoLab нь хүнсний бүтээгдэхүүн дэх биологийн идэвхт нэгдлүүдийг орчин үеийн аналитик тоног төхөөрөмжөөр нарийвчлалтай тодорхойлон, бүтээгдэхүүний тэжээллэг чанар, аюулгүй байдал, чанарын баталгааг хангах цогц үйлчилгээ үзүүлдэг.

Бидний шинжилгээ нь үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч болон хяналтын байгууллагуудад зориулсан чанарын хяналт, стандартын нийцэл, шошгололтын баталгаажуулалт-д чиглэнэ.

УСАНД УУСДАГ АМИН ДЭМ – 10 ҮЗҮҮЛЭЛТ

- HPLC болон спектрофотометрийн аргаар тодорхойлно
- Тэжээллэг чанарын баталгаажуулалт
- Шошгын мэдээллийн үнэн зөвийг шалгах
- Импорт, экспортын стандартын шаардлагад нийцлийг үнэлэх

Усанд уусдаг амин дэмийн агууламж нь бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл, боловсруулалтын технологиос хамааран өөрчлөгдөх тул тогтмол хяналт шаардлагатай.

ТОСОНД УУСДАГ АМИН ДЭМ – 4 ҮЗҮҮЛЭЛТ

- Өндөр мэдрэмжит HPLC төхөөрөмжөөр тодорхойлдог.
- Бага агууламжийг нарийвчлалтай илрүүлэх
- Хэтрэлт болон дутуу агууламжийг хянах
- Биологийн идэвхит бүтээгдэхүүн, тосон суурьтай бүтээгдэхүүнд тохиромжтой
- Тосонд уусдаг амин дэмийн хэт агууламж нь эрүүл мэндийн эрсдэл үүсгэж болзошгүй тул чанарын хяналт онцгой ач холбогдолтой.

АМИН ХҮЧИЛ – 17 ҮЗҮҮЛЭЛТ

- Уургийн чанар, биологийн үнэлэмж тодорхойлох
- Спортын нэмэлт бүтээгдэхүүн, сүү, мах, үр тарианд тохиромжтой
- GC/HPLC суурьтай анализ

КАФЕЙН ТОДОРХОЙЛОЛТ

- GC-FID / HPLC аргаар тодорхойлно
- Ундаа, кофе, энергийн бүтээгдэхүүнд тохиромжтой
- Стандартын дээд хязгаарын хяналт
- Шошгололтын баталгаажуулалт

ЯАГААД INNOLAB-ИЙГ СОНГОХ ВЭ?

- Орчин үеийн аналитик тоног төхөөрөмж 40+ (HPLC, GC, ICP-OES, IC, UV-Vis.)
- Туршлагатай химич, судлаачдын баг
- Чанарын хяналтын дотоод тогтолцоо
- Хурдан гүйцэтгэл, найдвартай үр дүн
- Үйлдвэрлэгчдэд зориулсан техникийн зөвлөгөө

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

- Хүнсний бүтээгдэхүүн дэх амин дэм, амин хүчил болон биологийн идэвхт нэгдлүүдийг шинжлэх нь:
- ✓ Бүтээгдэхүүний тэжээллэг чанарыг үнэлэх
- ✓ Хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах
- ✓ Хүнсний аюулгүй байдлыг хангах
- ✓ Импорт, экспортын шаардлагыг биелүүлэх
- ✓ Брэндийн нэр хүндийг хамгаалах

ЧАНАР



Хүнс, ус, хөрс, түүхий эд болон хүрээлэн буй орчин дахь органик бохирдуулагч нэгдлүүдийг өндөр мэдрэмжит аналитик аргаар тодорхойлон шинжилдэг.

Органик бохирдуулагчид нь бага агууламжтай ч хүний эрүүл мэнд, байгаль орчинд удаан хугацааны сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул стандартын дагуу нарийвчилсан хяналт шаарддаг. Бид дараах үндсэн бүлгийн шинжилгээг гүйцэтгэж байна:

ПЕСТИЦИДИЙН ҮЛДЭГДЭЛ – 205 ҮЗҮҮЛЭЛТ

- Жимс, хүнсний ногоо, үр тариа, малын гаралтай бүтээгдэхүүн
- GC-MS суурьтай шинжилгээ
- Европын холбооны шинжилгээний стандарт
- Олон улсын MRL стандартын дагуу үнэлгээ
- Экспорт, импортын шаардлагад нийцэл
- Пестицидийн үлдэгдэл нь архаг хордлого, дааврын өөрчлөлт, хавдрын эрсдэлтэй холбоотой тул тогтмол хяналт зайлшгүй шаардлагатай.

ОЛОН ЦАГИРГАТ ҮНЭРТ НҮҮРСУСТӨРӨГЧ (PAHs) – 17 ҮЗҮҮЛЭЛТ

- Шаталтын гаралтай бохирдуулагч
- Мах, тос, утаат бүтээгдэхүүн, хөрс, усанд илэрч болно
- GC-MS өндөр мэдрэмжит тодорхойлолт
- Хавдар үүсгэгч эрсдэлийн үнэлгээ
- PAHs нь олон улсын хэмжээнд хяналтанд байдаг канцероген ангиллын нэгдлүүд юм.

ПОЛИХЛОРТ БИФЕНИЛ (PCBs) – 20 ҮЗҮҮЛЭЛТ

- Байгальд удаан задрах органик бохирдуулагч
- Ус, хөрс, тослог хүнсний бүтээгдэхүүнд илэрнэ
- Байгаль орчны мониторинг
- POPs хяналтын хүрээнд үнэлгээ
- PCBs нь биоаккумуляци үүсгэх чадвартай тул урт хугацааны экологийн эрсдэлтэй.

ФЕНОЛЫН НЭГДЛҮҮД – 17 ҮЗҮҮЛЭЛТ

- Үйлдвэрийн гаралтай органик бохирдуулагч
- Ус, хөрс, үйлдвэрийн хаягдалд илэрнэ
- GC/ HPLC аргаар тодорхойлолт
- Усны чанарын стандартын нийцэл
- Фенолын нэгдлүүд нь хортой, экотоксик нөлөө үзүүлэх боломжтой.

ШИНЖИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Органик бохирдуулагчийн шинжилгээ нь:

- ✓ Хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах
- ✓ Хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах
- ✓ Байгаль орчны эрсдэлийг бууруулах
- ✓ Экспортын шаардлага хангах
- ✓ Төрийн хяналт, аудитын шаардлагад нийцэх

МАНАЙ ДАВУУ ТАЛ

- Итгэмжлэлийн хүрээнд гүйцэтгэх боломжтой үзүүлэлтүүд
- Орчин үеийн GC-MS/ HPLC / ICP-OES / IC тоног төхөөрөмж
- Туршлагатай аналитик химичдийн баг
- Дотоод чанарын хяналтын тогтолцоо
- Хурдан гүйцэтгэл, баталгаатай үр дүн

АЮУЛГҮЙ БАЙДАЛ





ИННО ЛАБОРАТОРИЙН 5 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ БАЙНА.

Инно Лаборатори нь хэрэглэгчдийн өндөр мэдрэмжит аналитик тоног төхөөрөмжид оруулж буй хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлэх, шинжилгээний чадавхийг дотоодын түвшинд бэхжүүлэх, хүнсний аюулгүй байдлын шинжилгээний нэр төрлийг төрөлжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан.

Бид анх Agilent Technologies компанийн GC/MS болон HPLC платформд суурилан иж бүрэн лабораторийн үйл ажиллагааг эхлүүлж, органик бодисын нарийвчилсан шинжилгээ, аргачлал хөгжүүлэлт, сургалт, зөвлөх үйлчилгээний чиглэлээр тогтвортой хөгжиж ирсэн бол өнөөдөр Agilent Technologies компанийн ICP-OES, Shine брэндийн IC зэрэг томоохон тоног төхөөрөмжөөр лабораторийн чадавхаа бэхжүүлэн өргөжсөөр байна.



**Инно лаборатори нь дэмжин ажилласан салбарын мэргэжилтнүүд,
хамтран ажилласан харилцагч байгууллагуудын маань хамтран
бүтээсэн үр дүн, үнэ цэн билээ.
Та бүхэндээ маш их баярлалаа.**